

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”-НД
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУА-2024/26-9-ШТА-ГА

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439
Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Ихбаяр
Аудитор Ж.Угтахбаяр
Аудитор Д.Должинсүрэн
Утас: 7059-3113

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
	График, хүснэгт, хавсралт зургийн товч	8-9
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан боловч нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс бусад орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.</u>	10
Аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ	1.1 Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хандив тусламжийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, зарим сумд тогтвортой амьжиргаа-3 төслөөс олгож буй урамшууллыг авах боломжийг алдсан байна.	10-12
Ахлах аудитор Д.Ихбаяр	1.2 Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгаагүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй, зураг төсөвгүй 5.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.	13-15
Аудитор Ж.Угтахбаяр Д.Должинсүрэн	<u>Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ үр нөлөөтэй байна.</u>	16
	2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж, багцад хуваан шууд худалдан авалтын аргыг ашиглаж байна.	16-18
	2.2 ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй байна.	18-19
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593113 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.3 Зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, хяналт сул байна .	19-21
ХАЯГ:	<u>Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж байгаа боловч иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажил хангалтгүй байна.</u>	21
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 210 тоот	3.1 ОНХС-ийн зарцуулалтын хяналтад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хангалтгүй, зарим ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	21-22
	3.2 ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн ч цахим хуудсанд ил тод мэдээлэх байдал хангалтгүй байна.	22-24
	Дүгнэлт	25
	Зөвлөмж	26
2024 оны 7 дугаар сар	Санал тайлбар	27
	Тайлангийн хавсралтууд	28-41



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/16

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1, 1.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9, 19 дүгээр зүйлийн 19.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУА-2024/26-9-ШТА-ГА/ -г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага) –ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт зарцуулалт үр дүн, үр нөлөө”-нд хийсэн аудитын тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, Дундговь аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2024 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор /Д.Ихбаяр/, аудитор /Ж.Угтахбаяр/, /Д.Должинсүрэн/ нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Т.Оюун-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЖГҮ	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНОХА	Олон нийтийн оролцоотой худалдан авалт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ЭДЦС	Эрдмийн далай цогцолбор сургууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ШТС	Шатахуун түгээх станц
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УМС	Удирдлага мэдээллийн систем

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн
эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 9.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу нэгдсэн удирдамжаар “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн үр нөлөөнд аудит хийж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийг бууруулах талаар санал, зөвлөмж боловсруулан аудитын дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/;
- ❖ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ❖ МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- ❖ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- ❖ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”

Аудитын хамарсан хүрээ:

- ❖ Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- ❖ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- ❖ Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- ❖ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аймгийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын СТСХ, ХБТХОХ, 15 сумын Засаг дарга, орлогч дарга, санхүүгийн ажилтнууд, ОНХС-ийн баримт материалыг хамруулсан. Орон нутгийн хөгжлийн санд 2023 онд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаарх ажлын тайлан, анхан шатны болон НББ-ийн журнал бусад холбогдох материал, эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ. Мөн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн.

Аудитын явцад аймгийн төв болон Сайнцагаан, Эрдэнэдалай, Хулд, Сайхан-Овоо, Адаацаг сумдад ажиллаж төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, аудитын 1-р нэгжийн ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн, Ж.Угтахбаяр нар 2024 оны 5 дугаар сарын 20-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд хийж, гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

Аудитыг гүйцэтгэх хугацаа бага, ажлын ачаалал их зэргээс шалтгаалж аудитын үе шатны ажил удааширч, аудитыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэхэд хүндрэлтэй байсан. Мөн аудитын явцад Эрдэнэдалай сумын Засаг даргын орлогч О.Базаррагчаа нь тус суманд ажиллах томилолтын удирдамжийг урьдчилан хүргүүлсэн байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажилдаа ирээгүй, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөөгүй нь аудит хийх нөхцөл боломжоор хангаагүй, төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан тул тус албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг нь хангууллаа.

Аудитын дүн

Аудитаар нийт 4,343.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 81.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 2 албан шаардлага, 4,262.1 сая төгрөгийн нийт 8 заалт бүхий зөвлөмжийг холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүллээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймаг, сумдын ОНХС 2023 онд ОНХНС-аас 10,918.0 сая, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 645.4 сая, малын тоо толгойн албан татварын орлогоос 1,180.4 сая, ОНХС-ийн 2022 оны үлдэгдлээс 4,063.0 сая, хандив тусламжаар 276.7 сая, бусад эх үүсвэрээс 184.2 сая, нийт 17,267.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, гүйцэтгэлээр 12,788.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймаг, сумдад ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд болон он дамжин хэрэгжүүлэх нийт 410 төсөл, арга хэмжээг баталжээ. Төлөвлөсөн ажлын 72.2 хувь буюу 296 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 5.4 хувь буюу 22 төсөл арга хэмжээ дутуу буюу 40-80 хувьтай хэрэгжиж, 22.4 хувь буюу 92 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна Энэ нь малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, зураг төсөв нь хийгдэж амжаагүй эсвэл зураг төсөвт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон, өөр санхүүгийн эх үүсвэрээр хийгдэхээр болсон, захиалагчаас хийгдэх шаардлагагүй гэж үзсэн зэргээс шалтгаалжээ. /Хавсралт № 8/

График товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	ОНХС -ийн 2023 орлогын гүйцэтгэл /сая төгрөгөөр/	10
График 2	Иргэдээс санал асуулга авсан хэлбэр, тоон үзүүлэлт	12
График 3	Хэрэгжсэн ТАХ-ний ангилал	17
График 4	ОНХС-аар хийгдсэн ажлын гүйцэтгэл	19
График 5	2023 онд хэрэгжээгүй ТАХ-ны шалтгааны үзүүлэлт	19
График 6	Мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгээгүй ТАХ-ны үзүүлэлт /Сумд/	21
График 7	УМС-ийн мэдээллийн системд мэдээлэл оруулсан гүйцэтгэл	23

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЖГҮ-гээр хангалтгүй үнэлэгдэж, урамшуулалд хамрагдаагүй сумд болон авах "боломж" -той байсан санхүүжилтийн дүн	11
Хүснэгт 2	Иргэдээс авсан саналын нэгтгэл /сум тус бүрээр/	12
Хүснэгт 3	Худалдан авах ажиллагааны ангилал	15

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	ОНХС-ийн 2023 оны төсөвт аймгийн ИТХ-ын тогтоолоор хийгдсэн нэмэлт өөрчлөлт, тодотголын судалгаа	26
Хавсралт 2	Дундговь аймгийн ОНХС-ийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт	27
Хавсралт 3	Тогтвортой амьжиргаа төслөөс сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн ба олгосон урамшууллын судалгаа /2017-2023 он/	28
Хавсралт 4	Дундговь аймгийн 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс авсан саналын судалгаа	29
Хавсралт 5	ТЭЗҮ, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүй, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй зөрчилд өгсөн албан шаардлагын жагсаалт	30-31
Хавсралт 6	Дундговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа /батлагдсан төсвөөр/	32

Хавсралт 7	Дундговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа /Гүйцэтгэлээр/	32
Хавсралт 8	Дундговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	33
Хавсралт 9	Дундговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгийн бүртгэл	33
Хавсралт 10	Дундговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг УМС-д оруулсан байдал	34
Хавсралт 11	Дундговь аймгийн 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зориулалт, гүйцэтгэл, тайлагналд тавьсан хяналт	34

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Эрдэнэдалай сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 502.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”-ийн тохижилт	36
Зураг 2	“Ундны усны чанар, аюулгүй байдал, хүрэлцээ, хангамжийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу Эрдэнэдалай, Адаацаг, Өлзийт сумдад хийгдсэн ус цэвэршүүлэгч	37
Зураг 3	2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс ашиглалтгүй байгаа хөрөнгийн судалгаа	38
Зураг 4, Зураг 5	ОНХС-аар хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах шаардлагатай хөрөнгүүд	39-40



БҮЛЭГ 1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан боловч нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс бусад орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

1.1 ОНХС-Д ТӨВЛӨРҮҮЛЭХ ХАНДИВ ТУСЛАМЖИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ, ЗАРИМ СУМД ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА-3 ТӨСЛӨӨС ОЛГОЖ БУЙ УРАМШУУЛЛЫГ АВАХ БОЛОМЖИЙГ АЛДСАН БАЙНА

Аймгийн ИТХ-ын 2022 оны 04 дүгээр тогтоолоор ОНХС-ийн 2023 оны орлогыг 15,311.6 сая төгрөгөөр баталсныг 2023 оны 25 дугаар тогтоолоор 18,535.7 сая төгрөг болгон 3,224.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Энэ нь ОНХНС-аас аймгийн ОНХС-д хуваарилсан орлогын шилжүүлгийг 2,059.4 сая төгрөгөөр, зарим сумд өмнөх оны үлдэгдэл болон малын тоо толгойн албан татвар, хандив тусламжийн орлогыг 1,164.7 сая төгрөгөөр нэмсэнтэй холбоотой байна. /Хавсралт №1/

Тус онд ОНХНС-аас аймгийн ОНХС-д нийт 11,875.4 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилсны 5.4 хувь буюу 645.4 сая төгрөгийг “Тогтвортой амьжиргаа-3” төслийн дэмжлэг, жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал эзэлж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Дундговь аймагт ОНХНС-аас Төсвийн тухай хуулийн 59.2, 59.3-т заасан хувь, итгэлцүүрийн дагуу /50.7 хувь буюу 6,024.1 сая төгрөгийг сумдад, 49.3 хувь буюу 5,851.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-д / 11,875.4 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор баталсан байна.

ОНХНС-аас олгох шилжүүлгээс гадна аймаг, сумдын ОНХС-ийн 2022 оны үлдэгдлээс 4,006.4 сая төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогоос 1,619.9 сая төгрөг, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу олгосон хандив, тусламжийн орлогоос 891.7 сая төгрөг, бусад орлогоос 142.3 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна. /Хавсралт №2/


Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлж, зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн нь 2023 оны ОНХС-ийн орлого бүрдүүлэлтийн хувьд онцлог байна. Гэвч Аймгийн ОНХС болон Өлзийт, Өндөршил сумдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар тус орлогын эх үүсвэрийг төлөвлөөгүй, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. Тухайлбал тус онд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон 281.4 сая төгрөгийн хандив, тусламжийг аймаг, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, урсгал зардалд зарцуулсан байна..

Мөн 2023 онд аймаг, сумдын засаг дарга нар 18 тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар 650.0 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Нийт хандив, тусламжаас 220.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-д төвлөрүүлж, 430.0 сая төгрөгийг “Уяхан замбуу тивийн наран” урлаг болон бусад арга хэмжээнд зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.2.5¹, 60.2.9²-д заасныг зөрчиж, орон нутгийн хөгжлийг дэмжихэд зориулан олгогдсон хандив тусламжийг зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна. Хуульд заасны дагуу дээрх хандив, тусламжийг ОНХС-гийн дансанд хүлээн авч орон нутгийн хөгжлийг дэмжих арга хэмжээнд зарцуулж байх зөвлөмжийг Дундговь аймгийн Засаг даргад Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн байна.

¹ Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

² Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

График 1



Тус онд ОНХС-д улсын төсвөөс 11,563.4 сая, урьд оны үлдэгдэл 4,063.0 сая, малын тоо толгойн албан татварын орлогоос 1,180.4 сая, хандив, тусламжийн орлогоос 276.7 сая, бусад орлогоос 184.2 сая, нийт 17,267.7 сая төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэлээр 12,788.4 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 4,479.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орлогын гүйцэтгэлийг авч үзэхэд малын тоо толгойн албан татварын орлого 439.5 сая төгрөгөөр буюу 27.1 хувь, ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 312.0 сая төгрөгөөр буюу 2.6 хувь, хандив тусламжийн орлого 615.0 сая төгрөгөөр буюу 69.0 хувиар тус тус тасарч, өмнөх оны үлдэгдэл болон бусад

орлого 1.4-29.4 хувиар давж биелжээ. /График 1/

Давж биелсэн орлогын хувьд :

- Өмнөх оны үлдэгдэл 1.4 хувиар давж биелсэн нь аймгийн ОНХС, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумд өмнөх оны үлдэгдлийг дутуу төлөвлөснөөс шалтгаалсан байна.
- Бусад орлого 29.4 хувиар давж биелсэн нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 8 сумын ОНХС-аас 133.9 сая төгрөгийн зориулалт бус зарцуулалтыг авлагаар тайлагнуулан залруулга хийж, авлагыг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Тасарсан орлогын хувьд :

- ОНХНС-аас 312.0 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон нь Дундговь аймгийн улсад төвлөрүүлсэн АМНАТ-ийн орлого тасарсантай холбоотой бөгөөд төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй Гурвансайхан сумын санхүүжилтийг нь хасаж хуваарилсан байна.
- Малын тоо толгойн албан татварын орлого 439.5 сая төгрөгөөр дутуу биелсэн нь өвөлжилт хүндэрч зарим сумдын татвар хураалт хойшилсон, зарим сумд орон тооны татварын байцаагчгүй байсан зэрэгтэй холбоотой байна.
- Хандив тусламжийн орлого 615.0 сая төгрөгөөр тасарсан нь аймаг болон Өлзийт сумын орлогын гүйцэтгэлтэй холбоотой байна.

Иймд аймаг, сумдын төсвийн төсөлд ОНХС-ийн орлогыг хуульд заасан нэр төрөл тус бүрээр /ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээс бусад/ тооцоолж төлөвлөх, биелэлтийг сайтар хангаж, сангийн орлогыг нэмэгдүүлэхэд санаачилга гарган ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Иймээс ОНХС-д төвлөрүүлэх орлогыг хуульд заасан нэр, төрөл тус бүрээр тооцон төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлэх, орлого бүрдүүлэлтэд хамаарах алба хаагч нарыг удирдлага арга зүйгээр хангаж, ажлын хариуцлагыг нь сайжруулж, сангийн орлогыг нэмэгдүүлэх асуудлаар үр дүнтэй ажил зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

"Тогтвортой амьжиргаа-3" төслөөс сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийдэг "Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ"-ээр анхны жил буюу 2016 онд 15 сумын дундаж үнэлгээ **37 хувьтай** байсан бол 2022 онд **72.8 хувь** болж өсжээ. 2023 онд Тогтвортой амьжиргаа -3 төслөөс 645.4 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал авсан боловч Өндөршил, Дэлгэрхангай сумд урамшуулал аваагүй байна. /Хүснэгт 1/

№	Сумдын нэр	ЖГҮ-гээр хангалтгүй үнэлэгдэж, урамшуулалд хамрагдаагүй сумд болон авах "боломж" -той байсан санхүүжилтийн дүн /мянган төгрөг/							Авах боломжтой байсан урамшууллын нийт дүн
		2016	2017	2018	2019	2020	2021	2022	
1	Дэлгэрцогт	21.2					6.8		28.0
2	Говь-Угтаал		31.5			12.2			43.7
3	Цагаандэлгэр		28.8		7.5	19.4			55.7
4	Өндөршил					40.0		15.5	55.5
5	Гурвансайхан	42.2	47.7		11.2				101.1
6	Өлзийт	33.4		8.7					42.1
7	Хулд			15.4			16.6		32.0
9	Дэлгэрхангай			15.3			16.9	19.8	52.0
10	Сайнцагаан	47.1							47.1
	Нийт	143.9	108.0	39.4	18.7	71.6	40.3	35.3	457.2

“Тогтвортой амьжиргаа -3” төслийг хэрэгжүүлж буй нэгжийн хувьд сумдын төсөв санхүүгийн удирдлагын бүтэн жилийн мөчлөг, “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн үйл ажиллагаанд төслөөс боловсруулсан зааварчилгааны дагуу сумдын засаглалын түвшинд 2016 оноос хойш жил бүр тасралтгүй үнэлгээ хийж байна.

2016-2022 онд хийгдсэн ЖГҮ-ний үр дүнд сумын ОНХС-д нийт **2,002.3** сая төгрөгийн урамшуулал олгож орон нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан байна. 2016-2022 онд хийгдсэн ЖГҮ-ээр Дэрэн, Баянжаргалан, Луус, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг сумд жил бүр урамшуулал авах болзлыг хангаж ажилласан байна. /Хавсралт № 3/

Харин бусад сумдын хувьд 1-3 жил хангалтгүй үнэлэгдэж төслийн санхүүжилтээр ОНХС-д буцалтгүй олгогдох урамшууллыг орон нутагтаа авах боломжийг алдсан байна. Хүснэгт:3–аас харахад Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрхангай сумд 3 жил, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Өндөршил, Өлзийт, Хулд сумд 2 жил, Сайнцагаан сум 1 жил хангалтгүй үнэлэгдэж аймгийн дүнгээр нийт **457.2** сая төгрөгийн урамшуулал авах боломжийг алдсан байна. Харин 2023 онд Дэлгэрхангай, Өндөршил сумд **35.3** сая төгрөгийн урамшуулал авах боломжийг алджээ. /ТА-3 төслөөс шалгуур хангасан сумдад урамшуулал олгодог аргачлалын дагуу тооцоолов./ Мөн 2023 оны ЖГҮ-гээр Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Гурвансайхан сумд хангалтгүй үнэлгээ авч 2024 онд **184.1** сая төгрөгийн урамшуулалт санхүүжилт авах боломжийг алдсан байна. Энэ нь сумдын Засаг дарга, ОНХС-ийн үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журмын хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулж байгаатай холбоотой бөгөөд ажилдаа хариуцлагагүй хандсан төрийн албан хаагч нарын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан сум орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх зорилго чиглэл алдагдах эрсдэл үүссэн байна. Мөн аймгийн ЗДТГ-аас ЖГҮ-ний үр дүнд дүн шинжилгээ хийж хангалтгүй үнэлэгдсэн сумдад хариуцлага тооцож, ажил сайжруулах арга хэмжээ авсан зүйл байхгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд 2 сум ЖГҮ-гээр хангалтгүй үнэлэгдсэн зөрчлийн нөхцөл, шалтгаан, орон нутгийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй үр дагаврыг тодорхойлж, урамшууллаа бүрэн авах нөхцөлийг бүрдүүлэх, ажилдаа хариуцлагагүй хандсан албан тушаалтнуудад хариуцлага тооцон, бүх сумдыг урамшууллаа бүрэн авах шаардлага тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

**1.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ТУСГААГҮЙ,
ИРГЭДИЙН САНАЛААР ДЭМЖИГДЭЭГҮЙ, ЗУРАГ ТӨСӨВГҮЙ 5.3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСАН БАЙНА.**

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, ТАХ-г төлөвлөхдөө иргэдээс саналыг авч, аймгийн чиг үүрэгт хамаарах саналын жагсаалтыг боловсруулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн Дундговь аймаг дахь нэгж нь 2018 оноос ОНХС-ийн үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулж, баг тус бүрд ОНХС-ийн талаар мэдээлэл хүргэх чиглүүлэгчийг бэлтгэн, чадавхжуулж ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажилд оролцсон байна.

2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, ТАХ-ний төлөвлөлтөд аймгийн хэмжээнд 15 сумын 14,847 өрхийн 30,628 иргэний 28.3 хувь буюу 8,138 иргэнээс саналыг авч, жагсаалт гаргаж баталгаажуулсан байна. Энэ нь 2021 онд авсан саналтай харьцуулахад 4.1 хувиар буурсан бөгөөд иргэдийн саналыг төлөөлөхүйц хангалттай түвшинд хүрээгүй, оролцоог бүрэн хангаж чадаагүй байна. Иргэдээс 2022 онд авсан саналыг сум тус бүрээр харуулбал:

Аудитад хамрагдсан сум	Багийн тоо	Өрхийн тоо /2021 он/	Хүн амын тоо/18 -аас дээш настай /	Санал авсан иргэний тоо	Хүснэгт:2 Санал авсан хувь
Адаацаг	5	804	1778	736	41.4
Баянжаргалан	3	455	868	297	34.2
Говь-Угтаал	4	491	1028	229	22.3
Гурвансайхан	5	687	1428	373	26.1
Дэлгэрхангай	4	712	1481	445	30.0
Дэлгэрцогт	3	577	1121	721	64.3
Дэрэн	4	628	1374	451	32.8
Луус	3	607	1303	347	26.6
Өлзийт	6	814	1619	423	26.1
Өндөршил	3	471	1047	404	38.6
Сайнцагаан	9	5009	9858	2307	23.4
Сайхан-Овоо	4	684	1807	468	25.9
Хулд	4	773	1569	541	34.5
Цагаандэлгэр	4	397	761	304	39.9
Эрдэнэдалай	6	1738	3586	623	17.4
Дүн	67	14847	30628	8669	28.3


Хурал, уулзалт болон цахим хэлбэрээр нийт **8,669** иргэдээс санал авахад сангийн хөрөнгөөр **477** хөрөнгө оруулалт ТАХ-г санхүүжүүлэх санал гаргасан боловч **86.0** хувь буюу **410** ТАХ нь батлагдаж, **142** ТАХ нь цуцлагдсан байна.

График 2

Иргэдээс авсан санал асуулгын дийлэнх буюу 70.8 хувийг санал асуулгын хуудсаар, 20.2 хувийг цахим хэлбэрээр, 9 хувийг бүлгийн ярилцлагын аргаар авсан байна. /График 2, Хавсралт 4/

2023 онд төлөвлөсөн **18,535.7** сая төгрөгийн өртөг бүхий **410** ТАХ-ээс **28.8** хувийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй, санал авч эрэмбэлэгдээгүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй,

Иргэдээс санал асуулга авсан
хэлбэр, тоон үзүүлэлт



шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй, магадлалаар баталгаажуулахгүй 157 ТАХ-нд 5,334.5 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3³ дахь хэсэг, 60.3.1⁴, 60.3.4⁵, 60.3.6⁶ дахь заалт, 63 дугаар зүйлийн 63.1⁷ дэх хэсэг, ЗГ-ын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2⁸ дахь заалт⁹, Сангийн сайдын 2021 оны 86 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 4.3.1¹⁰, 4.3.2¹¹, 4.3.3¹² дахь заалт, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2.5¹³ дахь заалтыг, тус тус зөрчсөн байна. Дээрх зөрчлүүд нь ОНХС-тай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны ажлын хариуцлага, аймаг сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч нар хяналтын байгууллагаас хууль тогтоомжийн хүрээнд тавьж буй шаардлагыг хүлээн авахгүй эрх мэдлээ хэтрүүлэн, хууль бус шийдвэр гаргаж байгаатай холбоотой бөгөөд сангийн хөрөнгө үр ашиггүй, зориулалт бус ТАХ-нд зарцуулах эрсдэлийг бий болгож байна.

Дараах ТЕЗ, ИТХ сангийн хөрөнгийг иргэдийн саналаар дэмжигдээгүй, санал авч эрэмбэлэгдээгүй 28 ТАХ-нд 824.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж баталсан байна. Тухайлбал:

СТ-ын аудитаар илэрсэн асуудал:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Луус суманд борлуулалтын цэг шинээр барих”, “Өлзийт сумын хүүхэд залуучуудын автомашингүй-ногоон орчин жишиг тоглоомын талбай”, “Сайнцагаан сумын ЗДТГ-ын засвар”, “Стандарт хэмжил зүйн газрын барилгын дээврийн засвар” зэрэг 4 ажил - **583.1 сая төгрөг**
- Сайнцагаан сумын ЭДЦС-ийн “Насан туршийн боловсролын кабинетад тоног төхөөрөмж авах”, “Хүнсний захад МЭШ-ний лаборатори байгуулах”, “8 дугаар цэцэрлэгт стандарт хүүхдийн тоглоом нийлүүлэх”, “Хүмүүнлэг сургуульд тестийн шалгалт засах программ, сканер тоног төхөөрөмж авах”, “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл урлагийг дэмжих зардал”, “Нийтийн биеийн тамир спортыг дэмжих зардал”, “Газрын харилцааны нэгдсэн мэдээллийн киоск машин авах”, “6 дугаар цэцэрлэгийн гадна автомашины зогсоол байгуулах”, “Говийн ирээдүй цогцолбор сургуулийн спорт заалны засвар”, “ЭДЦС-ийн сургалтын хэрэгцээнд сурагчийн ширээ, сандал”, “Хогийн менежментийг сайжруулах тээврийн хэрэгсэл”, “Цэгцбилиг сургуулийн уулзварын тохижилт, бетоны ажил” зэрэг 18 ажил - **241.4 сая төгрөг**
- Гурвансайхан сумын “Универсал трактор”, “Замын гэрэлтүүлэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, туузан гэрэл”, “Сумын төвийн цэвэрлэх байгууламж шинээр барих”, “Шинэ дотуур байрны тохижилт” зэрэг 6 ажил

³ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно

⁴ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга хэмжээ

⁵ Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

⁶ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

⁷ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна

⁸ Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөл болон төсөвтэй байх

⁹ Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөл болон төсөвтэй байх

¹⁰ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

¹¹ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх.

¹² Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хууль заасны дагуу зураг төсөв, техникийн эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

¹³ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхын санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална/ум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхын санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална.

ОНХС-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дээрх зөрчлүүдийг арилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад **824.5 сая төгрөгийн албан шаардлага** хүргүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө саналын хуудсаар нээлттэй санал асуулга авч, эрэмбэлэн нэгтгэж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлж байгаа боловч иргэдийн хамралт муу, оролцоо хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Цаашид ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийг сум баг хорооны түвшинд чанартай зохион байгуулж, иргэд олон нийтийг өргөн хүрээтэй хамруулж, олон нийтийн оролцоог хангаж ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад илэрсэн зөрчил болон судалгааны дүнгээс харахад ОНХС-ийн үйл ажиллагааг анхан шатанд төлөвлөх ажил хангалтгүйгээс шалтгаалж төсвийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлж, иргэдийн оролцоо хяналтыг бий болгох ОНХС-ийн зорилт бүрэн хангагдаагүй хэвээрээ сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Сангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй **40 ТАХ-нд 1,138.7 сая зарцуулахаар төлөвлөж баталсан**. Тухайлбал:

СТ-ын аудитаар илэрсэн асуудал:

- Дэрэн сумын “Цэцэрлэгийн цэвэр ус халаалтын шугамын засвар”, “Сумын төвийн гүний худгийн засвар”, “Сумын түүхийн танхимын тохижилт засвар”, “Сургуулийн хүнсний агуулахын тохижилт”, “Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж”, “Дотуур байрын сурагчдын зөөлөн эдлэл хэрэгсэл”, “Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн машин”, “Малчдын сургалт сурталчилгаа”, “Тэмт халдлага гамшигаас хамгаалах” зэрэг **16 ажил - 211.5 сая төгрөг**
- Баянжаргалан сумын “Спорт заалны их засвар”, “Биеийн тамир, спортын хэрэглэгдэхүүн”, “Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх”, “Нярайн шарлагыг хэмжих төхөөрөмж”, “Малчдад зориулсан сургалт сурталчилгаа”, “Вакцины хөргүүр, хөлдөөгч” зэрэг **7 ажил - 286.3 сая төгрөг**
- Дэлгэрхангай сумын “Наадмын талбайн тохижилтыг нэмэгдүүлэх”, “Угтах үдэх хаалганы орчмын тохижилт”, “Дотуур байрны тохижилт хийх”, “Зөөврийн багийн төв худалдан авах”, “Гүн өрмийн худаг гаргах”, “Хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах”, “Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх ажил” зэрэг **17 ажил - 680.9 сая төгрөг**

ОНХС-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дээрх **1,138.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар ТЕЗ нарт хугацаатай албан шаардлага** хүргүүлсэн байна.

Аймаг, сумын ТЕЗ, ИТХ сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, ТАХ-г холбогдох хууль, журам, зааврын дагуу ТЭЗҮ, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүй, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй **87 ТАХ-нд 3,361.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, баталсан** байна. Энэ нь ТАХ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх, улмаар өөр хэрэгцээ шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх боломжийг хааж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Иймд ОНХС-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дээрх **3,361.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар ТЕЗ нарт хугацаатай 15 албан шаардлага** хүргүүлсэн байна.
/Хавсралт 5/



БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ үр нөлөөтэй байна.

2.1 ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХААС ЗАЙЛСХИЙЖ, БАГЦАД ХУВААН ШУУД ХУДАЛДАН АВАЛТЫН АРГЫГ АШИГЛАЖ БАЙНА.

Дундговь аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд нийт 18,535.7 сая төгрөгийн өртөгтэй 410 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс нийт төсвийн 86.4 хувь буюу 16,016.3 сая төгрөгийн 325 ТАХ-нд сонгон шалгаруулалт зарлаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, 2,519.4 сая төгрөгийн 85 ТАХ-ний сонгон шалгаруулалт зарлаагүй, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна. /Хавсралт 6/

Худалдан авах үйл ажиллагаа явуулсан ТАХ-г сонгон шалгаруулалтаар нь авч үзвэл 17.5 хувь буюу 57 ажлыг нээлттэй тендер, 16 хувь буюу 52 ажлыг харьцуулалтын арга, 64.6 хувь буюу 210 ажлыг шууд худалдан авалтын арга, 1.9 хувь буюу 6 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авалт зохион байгуулсан байна. /Хавсралт 6/

Хүснэгт № 3

Худалдан авсан арга	Тендер зарласан		ТАХ хэрэгжсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
НТШ	57	10,292.9	54	7,763.8
ХА	52	2,771.7	47	2,292.1
ШГБ	210	2,910.8	210	2,695.6
ОНОХА	6	40.9	6	36.9
	325	16,016.3	317	12,788.4

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарсан 7,763.8 сая төгрөгийн 54 ТАХ-г хэрэгжүүлж, 2 ТАХ-ний гэрээг цуцлан, 1 ТАХ-г шилжих хөрөнгөөр он дамжуулан хэрэгжүүлэхээр гэрээнд өөрчлөлт оруулсан байна. Харьцуулалтын аргаар шалгарсан 2,292.1 сая төгрөгийн 47 ТАХ-г хэрэгжүүлж, 4 ТАХ-г он дамжин

хэрэгжихээр нэмэлт гэрээ хийн, 1 ТАХ-ны гэрээг цуцалсан байна. Шууд худалдан авалтын 210 ТАХ-г анх батлагдсан төсвөөс 215.2 сая төгрөгөөр, ОНОХА-уудын 6 ТАХ-г батлагдсан төсвөөс 4.0 сая төгрөгөөр бууруулан гэрээг байгуулсан байна. /Хавсралт 7/

Худалдан авах ажиллагаа нь амжилттай зохион байгуулагдаж, гэрээ нь бүрэн хэрэгжсэн 296 ТАХ-нээс нийт 992.4 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна. /хавсралт 8/

Аймаг болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар сонгон шалгаруулалт, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- “Дэлгэрхангай” сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 80.0 сая төгрөгийн өртөгтэй “Мал угаалгын банн шинээр барих” 4 багц ажлын тендер шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй.
- “Эрдэнэдалай” сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Хүүхэд хөгжлийн ордны тохижилт” төсөл арга хэмжээнд нэмэлтээр 60.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, дагалдах хэрэгсэл, холболтын тоног төхөөрөмжийг нийлүүлэхдээ хууль, журмыг зөрчсөн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.4¹⁴, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.6¹⁵, 8.7.1¹⁶ - дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹⁴ /хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;/

¹⁵ /Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно./

¹⁶ /Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/

Иймд ОНХС-ийн хөрөнгийн худалдан авах ажиллагааг үр дүнтэй, хуулийн дагуу зохион байгуулаагүй сумдын Засаг дарга нарт зөрчлийг арилгаж, хуулийн дагуу ажиллах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

Харин гүйцэтгэлийн аудитаар сумдын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэхийг анхан шатны баримтаас хөөн шалгахад нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж, хөрөнгө оруулалтыг хэсэгчлэн, өртгийг бууруулан /20 сая төгрөгөөс бага/, хэд хэдэн багц болгон хувааж, ИТХ-аар батлуулан, шууд худалдан авалт хийсэн нь ашиг сонирхол үүсгэж болзошгүй байна. Тухайлбал:

- “Эрдэнэдалай” сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн нийт 27.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг “Уламжлалт эмнэлгийн тоног төхөөрөмж”, “Шүдний рентген” гэж 2 хуваан баталж, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг буруу сонгож босго үнийг мөрдөлгүй “Аюур мед дэвшил” ХХК-аас шууд худалдан авалт хийсэн.
- “Эрдэнэдалай” сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн нийт 24.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн гудамж, талбай тэгшилж, элс, шороог зайлуулах ажлыг “Гудамж талбай тэгшилж, цэгцлэх”, “Сумын төвийн лагерь гудамжны элс, шороог зайлуулах” гэж 2 хуваан баталж, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг буруу сонгож босго үнийг мөрдөлгүй иргэн Л.Бат-Эрдэнэтэй шууд гэрээ байгуулсан.
- “Сайнцагаан” сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн нийт 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Говийн тэнгэр хорооллын замын уулзварын зам засварын ажил”-ыг “Говийн тэнгэр хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт”, “Авто замын тохижилт, бетоны ажил” гэж 2 хуваан баталж, худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг буруу сонгож босго үнийг мөрдөлгүй “Мандал шилтгээн” ХХК болон иргэн Б.Энхтөр нартай гэрээ байгуулан, шууд худалдан авалт хийсэн.

Эрдэнэдалай сум “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно” гэсэн заалтыг эсрэгээр нь ашиглан өрсөлдөөнийг хязгаарлаж, багц болгон хуваасан ажлаа нэг иргэн, компанид давуу байдал бий болгож олгосон байна. Харин Сайнцагаан сумын хувьд Авто замын тухай хуулийн 20.1¹⁷, 28.4¹⁸-д заасан заалтыг зөрчиж, тусгай зөвшөөрөлгүй иргэнтэй гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгийн худалдан авах ажиллагааг үр дүнтэй, хуулийн дагуу зохион байгуулж ажиллах, авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Мөн аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар ИТХ-аар батлаагүй, зориулалт бус зардалд сангийн хөрөнгийг зарцуулсан дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- “Дэрэн” сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс шагнал урамшууллын зардалд 1.2 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоож буцаан төлүүлсэн;
- “Өлзийт” сумын орон нутгийн хөгжлийн сангаас иргэдэд буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулалд 23.2 сая төгрөгийг олгосон зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн;
- “Луус” сумын орон нутгийн хөгжлийн сангаас 2022 онд дутуу хийгдсэн “Ахуйн үйлчилгээний барилга”-ын ажлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг ОНХС-ийн 2023 оны төсвийн эх үүсвэрт тусган ИТХ-аар батлуулалгүй, шууд зарцуулсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн байна.

¹⁷ Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд холбогдох хууль, журмын дагуу захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.


¹⁸ Шинээр барьж байгуулсан авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа нь гүйцэтгэгч болон техник, технологийн хяналт тавьсан хуулийн этгээдэд тус бүр гурван жил байна.

Харин гүйцэтгэлийн аудитаар “Цагаандэлгэр” сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 81.8 мянган төгрөгийн усны шинжилгээний төлбөрийг ИТХ-аар батлуулалгүй шууд төлсөн зөрчил илэрсэн.

Иймд гүйцэтгэлийн аудитаар илэрсэн дээрх зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг Цагаандэлгэр сумын Засаг дарга хүргүүлээ.

2.2 ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

График 3 Хэрэгжсэн ТАХ-ын ангилал



Аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 12,788.4 сая төгрөгийн 317 ТАХ хэрэгжсэнээс 29.7 хувь буюу 3,798.5 сая төгрөгийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, шинжлэн ухаан, цахим технологид, 15.9 хувь буюу 2,028.8 сая төгрөгийг дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд, 26.5 хувь буюу 3,392.8 сая төгрөгийг орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад, 3.2 хувь буюу 405.2 сая төгрөгийн ундны усан хангамж,

эрүүл ахуйг сайжруулахад, 6.3 хувь буюу 809.9 сая төгрөгийг аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахад, 7.6 хувь буюу 975.2 сая төгрөгийг ажлын байр бий болгоход, 10.8 хувь буюу 1,378.0 сая төгрөгийг малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх ТАХ буюу хөдөө аж ахуйн салбарт зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд сайн жишиг болохуйц амжилттай хэрэгжүүлсэн дараах ТАХ-үүд байна.

- **Эрдэнэдалай** суманд орон нутгийн хөгжлийн сангийн 502.3 сая төгрөгөөр хуучин соёлын төвийн барилгыг засварлан, “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”-ийн тохижилтыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайн суманд хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, даам, шатар, бөх, бүжиг зэрэг урлаг спортын дугуйлан, номын сан, сургалтын танхимууд, автомат болон бусад тоглоомын цогцолбор төвтэй болсон байна. “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”-ийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулан 2024 оноос орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилсөн байна ТАХ-ний үр дүнд орон нутгийн 6 иргэнийг шинээр ажлын байртай болгожээ. /Зураг 1/
- Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 онд “Ундны усны чанар, аюулгүй байдал, хүрэлцээ, хангамжийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар “Ундны усны эх үүсвэрийн химийн найрлагад тохирсон ус шүүх төхөөрөмжийг суурилуулж, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулж, үр дүнг тооцож ажиллах” зөвлөмжийг өгсөн. Тус зөвлөмжийн хүрээнд 2023 онд **Эрдэнэдалай** сум 34.2 сая, **Адаацаг** сум 20.0 сая, **Өлзийт** сум 86.4 сая төгрөгөөр сумын төвийн худгуудад ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжүүд байршуулан, парк шинэчлэл хийсэн байна. /Зураг 2/

Дээрх 2 ажил нь иргэдийн ая тухтай, эрүүл амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлсэн сайн туршлага болохуйц үр дүнтэй ТАХ-нууд болсон байна.

Аудитаар Сайнцагаан, Эрдэнэдалай суманд хэрэгжсэн нийт 9 сая төгрөгийн төсөвтэй “Сумын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх” ажлын гүйцэтгэлийг шалгахад тус ажлыг хүлээн авсан актад “Хийсэн ажлын тайлан, гэрээний хэрэгжилтийг үнэлэн хүлээн авсан” тухай дурдсан боловч Эрдэнэдалай суманд хийсэн ажлын

тайлан байхгүй байлаа. Тус ажлын үр дүн, үр нөлөөний хувьд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит болон гүйцэтгэлийн аудитаар дараах байдалтай байна. Үүнд:

Санхүүгийн аудитаар илэрсэн асуудал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн үе шаттай холбоотой Эрдэнэдалай суманд 368.9 сая төгрөг, Сайнцагаан суманд 559.4 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн.

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн асуудал:


- Эрдэнэдалай суманд 75.6 сая төгрөгийн 2, Сайнцагаан суманд 113.9 сая төгрөгийн 6 ТАХ-нд мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй;
- Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад 2022 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар УМС-ийн мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн;
- Шилэн дансны цахим хуудсанд Эрдэнэдалай, Сайнцагаан сумд тухайн жилийн төсөв, гэрээний дүн, гүйцэтгэгч байгууллагын мэдээлэл, гүйцэтгэлийн зураг төсөв зэргийг мэдээлээгүй.

Илэрсэн зөрчлүүдээс харахад ТАХ-үүд нь ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал, хяналттай холбоотой зөрчлийг бууруулахад нөлөө үзүүлээгүй үр дүн, үр нөлөөгүй ажил болсон байна. Мөн дээрх зөвлөх үйлчилгээгээр хэрэгжүүлж байгаа ажил нь сумын Засаг даргын орлогчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлууд байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

2024 онд “Сумын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх” ажлыг Гурвансайхан, Дэлгэрхангай сумд хэрэгжүүлэхээр төлөвлөснийг аудитын явцад албан шаардлага, зөвлөмж өгч зөрчлийг арилгуулсан.

2.3 ЗАРИМ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ХЯНАЛТ СУЛ БАЙНА.

Аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 410 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 318 төсөл, арга хэмжээний гэрээ хийгдсэн байна. Үүний 95.5 хувь буюу 296 төсөл, арга хэмжээ бүрэн дууссан боловч 8 арга хэмжээний 447.5 сая төгрөгийг дутуу, 22 төсөл арга хэмжээ гүйцэтгэл дутуу, 1,627.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож дараа онд шилжсэн байна. /Хавсралт 8/




Худалдан авах үйл ажиллагаа явуулсан ч гэрээ цуцлагдан хэрэгжээгүй, худалдан авах үйл ажиллагаа огт явагдаагүй нийт 3,261.0 сая төгрөгийн 92 ТАХ-ний хэрэгжээгүй шалтгааныг тодруулахад:

График 5/сая.төг/

- Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжих 723.2 сая төгрөгийн 45 ТАХ хэрэгжээгүй нь тухайн орлогын ихэнх хувь нь мал тооллогоор буюу оны сүүлээр төвлөрдөг тул ТАХ-г өвлийн улиралд хэрэгжүүлэх боломжгүй болдог;

- 1,476.9 сая төгрөгийн 28 ТАХ нь маргаантай тендер шалгаруулалтаас болж хугацаа алдсан, гүйцэтгэгч компанийн буруугаас хуулийн байгууллагад шилжин, хэд хэдэн он дамжин хийгдэхээр төсөвлөгддөг;

- 1,060.9 сая төгрөгийн 18 ТАХ-нд зураг төсөв нь хийгдэж амжаагүй эсвэл зураг төсөвт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон, өөр санхүүгийн эх үүсвэрээр хийгдэхээр болсон, захиалагчаас хийгдэх шаардлагагүй гэж үзсэн ТАХ-г дараа онд шилжүүлэлгүй хассантай тус тус холбоотой байна. /Хавсралт 7/



Аудитаар аймаг болон Сайнцагаан, Хулд, Сайхан-овоо, Адаацаг, Эрдэнэдалай сумдын ОНХС-аар хийгдсэн 206 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон хөрөнгийн ашиглалтыг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

ОНХС-ын хөрөнгөөр 2023 онд бэлтгэсэн ашиглалтгүй байгаа дараах хөрөнгүүд байна.

- Эрдэнэдалай сум 19.0 сая төгрөгийн өртөгтэй “Уламжлалт эмнэлгийн тоног төхөөрөмж” худалдан авснаас 4.0 сая төгрөгийн шаардлага хангаагүй гүйлтийн зам, нийт 2.2 сая төгрөгийн 2 ширхэг дагалдах багаж хэрэгсэл дутуу хоргүйжүүлэх аппарат, нийт 1.6 сая төгрөгийн 2 ширхэг буруу заадаг автомат даралтын аппарат нийт 7.8 сая төгрөгийн ашиглах боломжгүй хөрөнгүүдийг хүлээн авсан. Мөн 8.0 сая төгрөгийн “Шүдний рентген”-ны дагалдаж багажийг дутуу авсан; /Зураг 3/

- Сайхан-овоо сум 8.9 сая төгрөгийн өртөгтэй нярайн дулаацуулах ширээг авсан боловч ашиглалтгүй агуулахад хадгалсан; /Зураг 3/

- Луус сум 16.8 сая төгрөгийн өртөгтэй хуванцар, гялгар уут пэрэслэгч машиныг 380 квт-д холбогдоогүй шалтгаанаар тус тус огт ашиглаагүй байна. /Зураг 3/

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд захиалагч шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн техник тодорхойлолтоо орчин нөхцөлтэйгөө уялдуулан судалгаа шинжилгээ хийхгүйгээр гаргасан нь орон нутгийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, ашиглалтгүй хөрөнгүүдийг бэлтгэх үндэс болж байна.

Иймд тоног төхөөрөмжийн ажиллах хүчин чадал, үзүүлэлтийг дутуу судалж бүрэн ашиглах боломжгүй хөрөнгө бэлтгэсэн төсөв захирагч нарт хариуцлага тооцож, ашиглалтгүй байгаа хөрөнгийн дутуу багаж хэрэгслийг авах, ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлэн, зориулалтын дагуу ашиглах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аудитаар ОНХС-аар бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой илэрсэн асуудлыг дурдвал:

- Сайнцагаан сумын 19.0 сая төгрөгийн өртөгтэй “Зүүн 4 замын гэрэл дохиог засварлах” ажил хийгдсэн боловч согтуу жолооч дайрч гэрлэн дохио ажиллахгүй болсон. Одоогоор уг хэрэг нь хуулийн байгууллагад шалгагдаж байна. /Зураг 4/

- Сайнцагаан сумын 407.9 сая төгрөгийн өртөгтэй /БМБХ ШТС-аас Шунхлай ШТС хүртэлх/ 3,5 км улсын чанартай авто замын гэрэлтүүлгийн ажлыг шалгахад нэг шонг машин дайрсан, зарим гэрлийн толгойн хүрээ эвдэрсэн; /Зураг 4/

- Аймгийн ОНХС-аар хийгдсэн 473.6 сая төгрөгийн өртөгтэй “Жишиг хүүхдийн тоглоом, амралт чөлөөт цаг өнгөрөөх талбай” /5 газарт хийгдсэн/ 3 тоглоомын газрын талбайн зөөлөвч резин нь салсан, арвижих багийн тоглоомын талбайн нэг хогийн сав байхгүй байсан.

Мөн зураг төсөв дээрх нийт 7.0 сая төгрөгийн өртөгтэй ногоон байгууламж нь хийгдээгүй; /Зураг 5/

- Аймгийн ОНХС-аар хийгдсэн 249.8 сая төгрөгийн өртөгтэй “Аймгийн төвийн нийтийн халуун усны их засвар”-ын ажлын усанд орох болон хувцас солих өрөө хоорондын тусгаарлах хана усанд норж доод талаасаа халцарч, мөөгөнцөртөх эрсдэлтэй болсон. Мөн байшингийн орох хэсгийн усны хаялга хагарч эвдэрсэн; /Зураг 5/

- Сайхан-Овоо сумын 142.0 сая төгрөгийн өртөгтэй “Наадмын талбайд сүүдрэвч сандлын тоог нэмэгдүүлэх, шинэчлэх” ажлын сүүдрэвчний төмөр дээврийн зарим хэсэг урагдаж хуурсан байсан. /Зураг 5/

Дээрх байдлаас харахад зарим хөрөнгийг дутуу хүлээн авсан, эзэмшигч байгууллагуудын хөрөнгийн хадгалалт, хамгаалалт муу байгаагаас хөрөнгийг засаж сэлбэх шаардлага үүсэж, төсвийн зардлыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Сумд ОНХС-аар хэрэгжүүлэх ТАХ-д иргэд, байгууллагууд санал өгөхдөө аймаг болон сумынхаа ард иргэдэд чиглэсэн орон нутгийн онцлогт тохирсон, зайлшгүй шаардлагатай, цаашид үр ашиг, үр нөлөө гаргах ТАХ-г сонгож байх шаардлагатай байна.

Иймд 2023 онд бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлж, ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажлыг гэрээний баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар хийлгүүлэх, зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж байгаа боловч иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажил хангалтгүй байна.

3.1 ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТАД ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО ХАНГАЛТГҮЙ, ЗАРИМ ТАХ-НИЙ ГҮЙЦЭТГЭЛД ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод аудит, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороод нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтийн явц болон гүйцэтгэлийн үр дүнд хяналтыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал Эрдэнэдалай, Адаацаг, Гурвансайхан, Луус, Өлзийт, Хулд, Баянжаргалан, Сайнцагаан сумдын хяналтын хороод нь хяналтын явцад илэрсэн хэрэгжээгүй болон дутуу, чанаргүй хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулах, хэрэгжилтийн ил тод байдлыг бүрэн мэдээлэх талаар зөвлөмжүүдийг хүргүүлж ажилласан байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Дэлгэрхангай, Өлзийт, Өндөршил, Хулд сумдын ОНХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж сангийн үйл ажиллагаа хууль журмын дагуу ажилласан гэсэн дүгнэлт өгсөн байна.


Харин иргэд, иргэний нийгмийн байгууллагууд ОНХС-ийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахгүй байна. Энэ нь иргэд олон нийтэд хууль, тогтоомжийн мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар сурталчилдаггүй, мэддэггүйтэй холбоотой бөгөөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх, хууль тогтоомжийг сурталчлах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгэх шаардлагатай аймгийн ОНХС-4,317.3 сая төгрөгийн ТАХ-нд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн бол сумдын ОНХС-ийн

41.6 хувь буюу 1,091.2 сая төгрөгийн 31 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хийлгээгүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 37.2¹⁹-т заасныг зөрчсөн байна. Мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгээгүй сумдыг графикаар харуулбал:

График 6

ОНХС-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар давтан гаргасан Говь-Угтаал, Баянжаргалан, Хулд, Дэлгэрхангай сумдын ажил хариуцсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцсон байна. /Хавсралт/



Дээрх зөрчил давтан гарсаар байгаа нь хөрөнгө оруулалт, ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, чанарын шаардлага хангахгүй хөрөнгө бэлтгэгдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгосоор байна.

Иймд аймаг, суманд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа ТАХ-ны захиалагчийн хяналтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг дарга хүргүүлээ.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар ОНХС-ийн хөрөнгийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 167.3 сая төгрөгийн 1, холбогдох хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой 2,611.0 сая төгрөгийн 15, бүртгэл тайлагналтай холбоотой 25.8 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд албан шаардлага хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.

Мөн холбогдох албан тушаалтанд ажил сайжруулах 7 зөвлөмжийг хүргүүлснээс 6 зөвлөмж хэрэгжсэн байна. Харин УМС-ийн мэдээллийн гүйцэтгэлийг бүрэн мэдээлсэн эсэхэд хяналт тавьж мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлсэн боловч Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумдын мэдээлэл оруулсан байдал хангалтгүй байна. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 96.1 хувьтай байна.

3.2. ОНХС-ИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАЖ, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН Ч ЦАХИМ ХУУДСАНД ИЛ ТОД МЭДЭЭЛЭХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэст “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2²⁰-т заасны дагуу хүргүүлж ажилласан байна. Мөн аймгийн ЗДТГ-аас аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн нэгтгэсэн тайланг журмын 9.9²¹-д заасны дагуу тайлагнан Монгол Улсын Сангийн яаманд хүргүүлжээ.

¹⁹ Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно

²⁰ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана

²¹ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгахаар заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийт 12,420.8 сая төгрөгийн ТАХ-нээс 12,320.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, байгууллагын даргын тушаал шийдвэрийг үндэслэн хөрөнгийн дансанд бүртгэж, 367.6 сая төгрөгийн 35 төсөл, арга хэмжээг урсгал зардлаар тайлагнасан байна. Хулд, Луус сумын 100.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, барилга, байгууламжийг комисс хүлээж аваагүй тул хөрөнгийг дансанд бүртгээгүй, авлагаар тусгасан байна.

Харин 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Говь-Угтаал сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 120.3 сая төгрөгийн хөрөнгө;
- Цагаандэлгэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 121.9 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэл тайланд тусгаагүй байсан зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, зөрчлийг арилгасан байна.


Нийт бүртгэсэн хөрөнгийн 1.5 хувийг боловсрол, эрүүл мэндийн салбарт, 2.7 хувийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын, 95.8 хувийг төрийн үйлчилгээний салбарын хөрөнгийн дансанд тус тус бүртгэсэн байна.

Тайлант онд аймгийн хэмжээнд УМС-д ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх 18,535.7 сая төгрөгийн 410 төсөл арга хэмжээг мэдээлэхээс гүйцэтгэлээр 50.2 хувь буюу 11,260.5 сая төгрөгийн 202 төсөл арга хэмжээний мэдээллийг оруулсан байна. Харин Гурвансайхан, Сайхан-Овоо сумд огт оруулаагүй, Өлзийт, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Сайнцагаан, Дэлгэрхангай, Говь-Угтаал сумд мэдээллээ дутуу оруулсан нь Сангийн сайдын 2021 онд батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.2²²-т заасныг зөрчсөн байна.

График 7

Энэ нь сумдын ОНХС хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагагүй байдалтай холбоотой бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ТАХ-ний гүйцэтгэлийн мэдээллийг иргэд олон нийтэд мэдээлэх ажил хангалтгүй байгааг харуулж байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд бүрэн мэдээлээгүй, журмын хэрэгжилт хангалтгүй байна.



Иймд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг олгож хэвшүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Тайлант хугацаанд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдлыг аймаг, сумдаар шалгахад мэдээллийн 76.2 хувийг хугацаанд нь, 20 хувийг хугацаа хоцроож, 3.8 хувийг мэдээлээгүй байна. Мэдээлэл оруулаагүй байгууллагуудыг

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана

²² Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ;

дурдвал аймгийн төв, Дэрэн, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумд 9 мэдээллийг байршуулаагүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулалтын хувь өндөр байгаа ч зарим сумдын төсөл, арга хэмжээний тоон мэдээлэл зөрүүтэй, дутуу мэдээлсэн зөрчлүүд илэрсэн. Тухайлбал Луус, Эрдэнэдалай, Сайнцагаан сумд тухайн жилийн төсөв, гэрээний дүн, гүйцэтгэгч байгууллагын мэдээлэл, гүйцэтгэлийн зураг төсөв зэргийг мэдээлээгүй байна.

Харин 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээлэлтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Баянжаргалан сумын орон нутгийн хөгжлийн сан шилэн дансны 159 мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1²³-т заасныг хэрэгжүүлээгүйгээс иргэд, олон нийтийг буруу мэдээллээр хангах нөхцөлийг бий болгож байна.

Иймд Дэрэн, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах, ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийг хуульд заасны дагуу үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх асуудлаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлж байна.

²³ мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг:1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан боловч нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс бусад орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

1. Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хандив тусламжийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, зарим сумд тогтвортой амьжиргаа-3 төслөөс олгож буй урамшууллыг авах боломжийг алдсан байна.
2. Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгаагүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй, зураг төсөвгүй, төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

Бүлэг:2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ үр нөлөөтэй байна.

3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж, багцад хуваан шууд худалдан авалтын аргыг ашиглаж байна.
4. Сайнцагаан сум замын уулзварын зам засварын ажил гүйцэтгэхдээ Авто замын тухай хуулийг зөрчин, тусгай зөвшөөрөлгүй иргэнтэй гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлсэн байна.
5. Зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, хяналт сул байна .

Бүлэг:3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж байгаа боловч иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажил хангалтгүй байна.

6. ОНХС-ийн зарцуулалтын хяналтад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хангалтгүй, зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, хяналт сул байна.
7. ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн ч цахим хуудсанд ил тод мэдээлэх байдал хангалтгүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Сумдын Засаг дарга нартай байгуулах хамтран ажиллах гэрээнд ОНХС-ийн урамшууллыг бүрэн авах шаардлагыг тусган, гүйцэтгэлийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах;
2. ОНХС-д төвлөрүүлэх орлогыг хуульд заасан нэр, төрөл тус бүрээр тооцон төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлэх, сангийн орлогыг нэмэгдүүлэх асуудлаар үр дүнтэй ажил зохион байгуулж, орлого бүрдүүлэлтэд хамаарах алба хаагч нарыг удирдлага арга зүйгээр хангаж, ажлын хариуцлагыг нь сайжруулах;
3. ОНХС-ийн хөрөнгийн худалдан авах ажиллагааг үр дүнтэй, хуулийн дагуу зохион байгуулж ажиллах;
4. Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр хийгдэх авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг холбогдох хууль, журмын дагуу тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлж байх;
5. Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр 2023 онд бэлтгэсэн тоног төхөөрөмжийн ажиллах хүчин чадал, үзүүлэлтийг дутуу судалж бүрэн ашиглах боломжгүй хөрөнгө бэлтгүүлсэн төсөв захирагч нарт хариуцлага тооцож, ашиглалтгүй байгаа хөрөнгийн дутуу багаж хэрэгслийг авах, ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлэн, зориулалтын дагуу ашиглаж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах;
6. Аймгийн хэмжээнд 2023 онд бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлж, ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажлыг гэрээний баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар хийлгүүлэх, зөрчлийг арилгах;
7. Аймаг, суманд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа ТАХ-ний захиалагчийн хяналтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;
8. ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг олгож хэвшүүлэх;

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд:

1. Сумдын Засаг дарга нар Шилэн дансны цахим системд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийг хуульд заасны дагуу хугацаанд нь сар бүр, иж бүрэн мэдээлж байгаа эсэх хяналт тавьж биелэлтийг хангуулж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.-д шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь аудитын үр дүнд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр заасан байдаг тул хуулийн хугацаанд төлөвлөгөөг ирүүлж, хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг хүсье.



Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090
Утас/Факс: 7059 2353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

Д.Ихбаяр
Саналыг туслам
тайлсан? батал-
жүүлсан? *ВН/05*

2024. 07.05 № 01/928
танай _____-ны № _____

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас
“Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Тухайн тайлангийн төсөлд ямар нэг санал,
тайлбаргүй болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

М.АНХБАЯР



**ОНХС-ийн 2023 оны төсөвт аймгийн ИТХ-ын тогтоолоор хийгдсэн нэмэлт
өөрчлөлт, тодотголын судалгаа**

№	Сумын нэрс	ОНХНС /мянган төгрөг/		Нийт батлагдсан төсөв /мянган төгрөг/	
		Сангийн ямнаас тооцсон орлогын шилжүүлэг /анхны /	Сангийн ямнаас тооцсон орлогын шилжүүлэг /тодотгосон/	Аймгийн ИТХ-ын 2022 оны 04 дүгээр тогтоолоор баталсан дүн /анхны/	Аймгийн ИТХ-ын 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан дүн /тодотгол-1 /
1	Адаацаг сум	268,198.3	332,703.1	528,116.9	592,621.7
2	Баянжаргалан сум	303,333.4	345,921.7	796,128.9	838,717.2
3	Говь-Угтаал сум	181,394.0	219,647.6	319,849.4	388,725.4
4	Гурвансайхан сум	398,778.5	453,809.9	882,439.7	963,556.4
5	Дэлгэрхангай сум	308,582.1	381,054.2	552,612.4	715,878.3
6	Дэлгэрцогт сум	129,232.9	160,669.4	206,902.5	248,339.0
7	Дэрэн сум	203,062.6	249,503.5	430,154.4	478,802.3
8	Луус сум	159,870.5	198,468.0	359,096.3	397,693.7
9	Өлзийт сум	539,161.1	644,846.7	1,196,611.4	1,383,979.5
10	Өндөршил сум	380,173.8	436,485.6	622,946.2	699,140.4
11	Сайнцагаан сум	637,724.8	793,841.5	843,724.8	999,841.5
12	Сайхан-Овоо сум	325,288.1	402,468.1	435,918.4	513,098.4
13	Хулд сум	363,267.5	427,043.3	494,514.5	611,695.1
14	Цагаандэлгэр сум	177,342.8	214,363.8	353,188.6	390,209.6
15	Эрдэнэдалай сум	619,041.6	763,341.1	1,233,621.6	1,427,921.1
	Сумын дүн	4,994,452.0	6,024,167.5	9,255,826.0	10,650,219.6
18	Аймгийн ОНХС	4,821,504.3	5,851,219.9	6,055,758.0	7,885,473.6
	Дүн	9,815,956.3	11,875,387.4	15,311,584.0	18,535,693.2

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНХС-ИЙН 2023 ОНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ

№	Сум, дүүргийн нэр	2023 оны ОНХНС болон улсын төсөв								2023 оны Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр						Нийт эх үүсвэр		Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн	ОНХСанг ийн харилцах дансны эцсийн үлдэгдэл
		ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ- ийн 60.2.1 орсон/		Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/		Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/		"Тогтвортой амжиргаа-3" төсөл /ТТХ- ийн 59.1.3/ Урамшуулал		ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС- ийн өмнөх оны үлдэгдэл		Бусад орлого		Малын тоо толгойн албан татвар					
																төлөв	гүйц		
1	Аймгийн төв	5,053.5	5,053.5	263.8	263.8	533.9	533.9	-	-	1,234.3	1,325.3	800.0	220.0	-	-	7,885.5	7,396.5	5,715.3	1,681.2
2	Адаацаг	278.1	278.1	1.5	1.5	5.7	5.7	47.4	47.4	199.9	206.4	-	-	60.0	62.5	592.6	601.6	396.1	205.4
3	Баянжаргалан	199.2	199.2	19.9	19.9	98.6	98.6	28.1	28.1	382.9	364.2	53.1	54.1	56.7	39.4	838.7	803.6	284.9	518.7
4	Говь-Угтаал	179.0	179.0	12.6	12.6	-	-	28.1	28.1	89.1	89.1	-	1.3	80.0	59.0	388.7	369.0	285.1	83.9
5	Гурвансайхан	257.5	102.9	39.9	-	117.5	-	38.9	38.9	361.7	409.8	-	20.0	148.1	90.0	963.6	661.6	148.7	512.9
6	Дэлгэрхангай	339.0	339.0	21.8	21.8	20.2	20.2	-	-	213.7	213.7	20.0	21.0	101.1	40.9	715.9	656.6	440.9	215.8
7	Дэлгэрцогт	133.6	133.6	0.1	0.1	-	-	26.9	26.9	8.1	17.8	10.0	10.0	69.6	69.6	248.3	258.1	227.6	30.5
8	Дэрэн	217.3	217.3	-	-	-	-	32.2	32.2	108.7	61.5	-	6.4	120.6	112.6	478.8	430.0	382.8	47.1
9	Луус	167.4	167.4	2.7	2.7	2.0	2.0	26.4	26.4	149.2	184.5	-	-	50.0	68.4	397.7	451.3	335.3	116.0
10	Өлзийт	457.4	457.4	32.4	32.4	81.0	81.0	74.1	74.1	500.9	474.9	81.7	46.7	156.6	119.0	1,384.0	1,285.4	779.3	506.1
11	Өндөршил	263.4	263.4	102.5	102.5	70.5	70.5	-	-	157.8	143.3	29.9	19.9	75.0	49.4	699.1	649.0	589.7	59.4
12	Сайнцагаан	677.2	677.2	-	-	10.4	10.4	106.3	106.3	40.0	15.5	-	19.8	166.0	100.7	999.8	929.9	807.3	122.6
13	Сайхан-Овоо	328.2	328.2	0.7	0.7	7.9	7.9	65.7	65.7	53.8	48.0	-	-	56.8	33.5	513.1	483.9	425.7	58.2
14	Хулд	298.4	298.4	38.9	38.9	44.3	44.3	45.5	45.5	115.4	115.4	19.3	19.3	50.0	50.0	611.7	611.7	495.0	116.7
15	Цагаандэлгэр	160.0	160.0	1.6	1.6	26.4	26.4	26.5	26.5	108.3	160.5	-	2.5	67.5	52.6	390.2	430.0	254.9	175.1
16	Эрдэнэдалай	625.4	625.4	1.8	1.8	36.8	36.8	99.3	99.3	282.6	233.2	20.0	20.0	362.0	233.0	1,427.9	1,249.6	1,219.8	29.8
		9,634.6	9,480.0	540.2	500.3	1,055.2	937.7	645.4	645.4	4,006.4	4,063.0	1,034.0	460.9	1,619.9	1,180.4	18,535.7	17,267.7	12,788.4	4,479.3

Хавсралт 3

ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА ТӨСЛӨӨС СУМДЫН ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН БА ОЛГОСОН УРАМШУУЛЛЫН СУДАЛГАА /2017-2023 ОН/

Сая төгрөгөөр

№	Сумдын нэр	2016 оны үнэлгээ			2017 оны үнэлгээ			2018 оны үнэлгээ			2019 оны үнэлгээ			2020 оны үнэлгээ			2021 оны үнэлгээ			2022 оны үнэлгээ			Нийт олгосон урамшуулал
		ЖГҮ оноо	Эрэм-бэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэм-бэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэм-бэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэм-бэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэм-бэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэм-бэ	Урам-шуулал	ЖГҮ оноо	Эрэм-бэ	Урам-шуулал	
1	Дэлгэрцогт	22%	253		45%	94	3.1	48%	184	6.3	52%	235	7.4	65%	137	9.8	48%	276		86%	31	26.9	53.6
2	Дэрэн	42%	61	34.4	42%	109	3.9	57%	111	9.3	64%	149	10.7	78%	41	14.1	78%	71	12.9	78%	90	32.2	117.6
3	Говь-Угтаал	33%	143	31.5	32%	214		55%	126	8.2	53%	230	9.3	45%	279		59%	210	9.4	78%	82	28.1	86.5
4	Цагаандэлгэр	38	93	28.8	32%	213		50%	161	7.5	41%	284		44%	289		88%	22	14.1	67%	193	26.5	76.9
5	Баянжаргалан	47%	33	30.6	68%	7	3.7	61%	87	8.2	59%	185	9.3	66%	122	12.3	66%	153	9.4	73%	132	28.1	101.6
6	Өндөршил	36%	108	34.4	64%	13	4.9	60%	93	11.6	64%	144	13.1	53%	230		59%	212	13.2	58%	270		77.2
7	Гурвансайхан	29%	192		33%	207		45%	208	11.2	47%	261		61%	178	17.1	81%	56	20.8	69%	181	38.9	88.0
8	Өлзийт	17%	294		36%	174	8.7	26%	308		54%	223	24.5	61%	177	32.5	61%	196	24.7	70%	167	74.1	164.6
9	Хулд	42%	63	39.8	52%	49	5.5	41%	239		78%	47	15.1	72%	77	20.0	55%	234		69%	169	45.5	125.9
10	Луус	46%	40	32.8	44%	95	3.9	49%	179	7.6	61%	172	8.7	74%	63	11.6	66%	155	8.8	75%	115	26.4	99.8
11	Дэлгэрхангай	37%	97	38.6	42%	111	5.7	40%	250		63%	158	17.0	64%	138	22.5	49%	268		59%	261		83.7
12	Сайхан-Овоо	48%	30	39.4	50%	60	5.4	48%	188	16.0	70%	100	18.1	65%	127	24.0	69%	130	18.3	83%	48	65.7	187.0
13	Эрдэнэдалай	49%	28	54.6	53%	46	8.2	50%	158	28.8	69%	112	32.9	68%	99	43.5	64%	170	33.1	70%	162	99.3	300.4
14	Адаацаг	47%	34	34.2	59%	26	4.5	68%	48	13.6	77%	49	15.7	78%	37	20.8	65%	164	15.8	89%	89	47.4	152.1
15	Сайнцагаан	28%	208		41%	124	12.9	54%	128	29.7	69%	104	35.2	63%	154	46.6	86%	31	56.8	68%	182	106.3	287.5
	Сумдын дундаж үнэлгээ болон нийт дүн	37%		399.1	46%		70.3	50%		158.1	9.2		217.0	9.6		274.9	9.9		237.4	72.8		645.4	2,002.3

*Шар болон бор өнгөөр будсан нь тухай онд хангалтгүй үнэлгээ авч урамшуулалд хамрагдаагүй сумдыг харуулсан

Хавсралт 4

ДУНДГОВЬ АЙМГИЙН 2023 ОНД ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ИРГЭДЭЭС АВСАН САНАЛЫН СУДАЛГАА

Сая төгрөгөөр

№	Сум, дүүргийн нэр	Саналын тоо /хэлбэр/			Нийт санал өгсөн иргэдийн тоо	Нийт санал /ажлаар/		Батлагдсан санал		Цуцлагдсан санал		Тайлбар
		Цахим	Бүлгийн ярилцлага	Цаасаар		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	3	4	5	6	7=4+5+6	8	9	10	11	12	13	14
1	Аймгийн төв	1443			1443	77	-	42	7885.5	35	(7,885.5)	
2	Адаацаг			714	714	26	1,015.0	15	592.6	11	422.4	
3	Баянжаргалан		98	190	288	25	1,631.0	14	838.7	11	792.3	
4	Говь-Угтаал			209	209	35	4,318.0	15	388.7	20	3,929.3	
5	Гурвансайхан		77	281	358	18	671.0	13	963.6	5	(292.6)	
6	Дэлгэрхангай		38	354	392	23	935.0	34	715.9	(11)	219.1	
7	Дэлгэрцогт	86	53	113	252	26	-	12	248.3	14	(248.3)	
8	Дэрэн			372	372	43	864.4	25	478.8	18	385.6	
9	Луус			332	332	20	985.0	18	397.7	2	587.3	
10	Өлзийт			385	385	28	1,706.0	39	1384.0	(11)	322.0	
11	Өндөршил		86	281	367	31	2,805.0	15	699.1	16	2,105.9	
12	Сайнцагаан	228	198	1327	1753	29	3,594.3	47	999.8	(18)	2,594.5	
13	Сайхан-Овоо		231	209	440	15	1,270.0	21	513.1	(6)	756.9	
14	Хулд			521	521	23	315.0	21	611.7	2	(296.7)	
15	Цагаандэлгэр			278	278	27	457.1	19	390.2	8	66.9	
16	Эрдэнэдалай			595	595	31	1,771.0	60	1427.9	(29)	343.1	
	Нийт дүн	1,757	781	6,161	8,699	477	22,337.8	410	18,535.7	67	3,802.1	-

Хавсралт 5

ТЭЗҮ, ТӨСВИЙН ТООЦООЛОЛ, ТӨСӨВТ НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ХЭРХЭН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ САНАЛ ТУСГААГҮЙ, МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТЭЭР
БАТАЛГААЖСАН ЗУРАГ, ТӨСӨВГҮЙ ЗӨРЧИЛД ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

Сая төгрөгөөр

№	Зөрчилтэй арга хэмжээ, сумын нэр	ТАХ-ны тоо	Мөнгөн дүн
Зураг төсөвгүй байхад жагсаалтад оруулж баталсан хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ			
1	Аймгийн ОНХС-ийн “Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил”, “Бизнес эрхлэгчдийг дэмжих төвийн их засвар”, “Сайнцагаан сумын 15-р байрны пасады засвар”, “Дэлгэрцогт сумын төрийн албан хаагчдын орон сууцны их засвар” зэрэг 4 ажил	4	612.9
2	Дэлгэрхангай сумын “Наадмын тайлбайн тохижилтыг нэмэгдүүлэх”, “Угтах үдэх хаалганы орчмын тохижилт”, “Дотуур байрны тохижилт хийх”, “Зөөврийн багийн төв худалдан авах”, “Гүн өрмийн худаг гаргах”, “Хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах”, “Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх ажил” зэрэг 15 ажил	15	0.0
3	Говь-Угтаал сумын “Гал унтраах байр барих”, “Багш нарын байрыг засварлах”, “Цэцэрлэгийн гадна болон хүүхдийн тоглоомын талбайн хаашаа барих”, “Дэнжийн хүүхдийн тоглоомын талбайн тохижилт”, “Гудамжны тохижилт”, “Мал угаалгын ванн барих” зэрэг 6 ажил - 270.7 сая төгрөг	6	270.7
4	Цагаандэлгэр сумын “Багш нарын байрны гадна талын засвар”, “Малчдын сургалт сурталчилгааны зардал” 2 ажил - 37.9 сая төгрөг	2	37.9
5	Гурвансайхан сумын “Универсаль трактор”, “Замын гэрэлтүүлэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, туузан гэрэл”, “Соёлын төвийн зураг төсөв”, “Эрүүл мэндийн барилгын өргөтгөлийн зураг төсөв”, “Сумын төвийн цэвэрлэх байгууламж шинээр барих”, “Шинэ дотуур байрны тохижилт”, “Малчдад зориулсан сургалт, зөвлөгөөн”, “Мал угаалгын ваннууд шинээр барих, засварлах” зэрэг 8 ажил	8	0.0
6	Хулд сумын “Сумын 9 цэгт иргэдэд мэдээлэл хүргэх, хяналтын камер, гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмж”, “Гудамж цэгцлэх”, “Наадмын талбайн тохижилт”, “Лед гэрэл усалгааны систем авах”, “Байгууллагуудын үзэмж сайжруулах гадна тохижилт”, “Газар усны нэрийн хээрийн тодруулалт”, Явуулын боловсон нойл”, Соёлын төвийн 00 бохирын асуудал” зэрэг 8 ажил	8	219.5
7	Эрдэнэдалай сумын “Ахуй үйлчилгээ ялтсан бойлуур тавих”, “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах 6-р баг”, “Хогийн цэгийн байнгын хяналт, ангилан ялгалтын цэг байгуулах”, “12 айлын орон сууц буулгаж талбай чөлөөлөх” зэрэг 4 ажил	4	67.3
8	Сайнцагаан сумын ЭДЦС-ийн “Насан туршийн боловсролын кабинетэд тоног төхөөрөмж авах”, “Хүнсний захад МЭШ-ний лаборатори байгуулах”, “8 цэцэрлэгт стандарт хүүхдийн тоглоом нийлүүлэх”, “Хүмүүнлэг сургуульд тестын шалгалт засах программ, скайнер тоног төхөөрөмж авах”, “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл урлагыг дэмжих зардал”, “Нийтийн биеийн тамир спортыг дэмжих зардал”, “Газрын харилцааны нэгдсэн мэдээллийн киоск машин авах”, “6-р цэцэрлэгийн гадна автомашины зогсоол байгуулах”, “Говийн ирээдүй цогцолбор сургуулийн спорт заалны засвар”, “ЭДЦС-ийн сургалтын хэрэгцээнд сурагчийн ширээ, сандал”, “Хогийн менежментийг сайжруулах тээврийн хэрэгсэл”, “Цэгцбилиг сургуулийн уулзварын тохижилт, бетоны ажил” зэрэг 20 ажил	20	278.6
	Дүн	67	1,486.9
Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй байхад жагсаалтад оруулж баталсан төсөл арга хэмжээ			

1	Дэлгэрцогт сумын “Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт” -ын ажил	1	116.3
2	Цагаандэлгэр сумын “Наадмын талбайг хашаажуулах, тохижилтыг нэмэгдүүлэх”, Нэг дүгээр багийн барилгын зураг зэрэг 3 ажил	3	39.0
3	Өндөршил сумын “Баяр наадмын талбайн асар шинээр барих” ажил	1	173.2
4	Өлзийт сумын “Гүн өрмийн худаг гаргах Загийн усны цав, Нанзан. Булаг сайр, Шар-Уул”, “Сумын төвийн цэвэр усны парк шинэчлэлийн ажил”, “Өвс тэжээлийн фонд засварлах ажил”, “Тагт 3-р баг Соёлын төвийн их засвар”, “Багш ажилчдын дотуур байрны сан техникийн ажил” зэрэг 5 ажил	5	381.2
5	Сайхан-Овоо сумын “Сумын төвийн хүүхэд залуучуудын талбайд чийрэгжүүлэлтийн төхөөрөмж суурилуулах. тохижуулалт ажил”, “Наадмын талбайд сүүдрэвч сандлын тоог нэмэгдүүлэх, шинэчилэх” зэрэг 5 ажил	5	241.5
6	Адаацаг сумын “Хуучин эмнэлгийн их засвар”-ын ажил	1	155.3
	Дүн	16	1,106.5
ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт зураг төсөв хийлгэх зардлыг арга хэмжээ тус бүрээр батлаагүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ			
1	Аймгийн ОНХС - 683.8 сая, Дэрэн сум - 16.5 сая, Дэлгэрхангай сум - 30.0 сая, Баянжаргалан сум – 37.6 сая төгрөгийн “Зураг төсөв хийлгэх” ажил нь ямар зураг төсөв хийлгэх нь тодорхой бус ерөнхий - 767.9 сая төгрөг	1	767.9
	Дүн	1	767.9
	Нийт дүн	84	3,361.3

Хавсралт 6

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, /Батлагдсан төсвөөр/
Сая төгрөгөөр

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Тайлант жилд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан ТАХ-ний	Үүнээс										
			Нээлттэй тендер шалгаруулалт		Онцгой журам				Олон нийтийн оролцоотой худалдан авалт		Худалдан авах ажиллагаа зарлаагүй		
					Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах						
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2			5	6	9	10	11	12	13	14	15	16
1	Аймгийн төв	42	7,885.5	32	7,238.0	9	447.5		-			1	200.0
2	Адаацаг	15	592.6	1	164.0	3	186.6	4	71.6			7	170.5
3	Баянжаргалан	14	838.7	2	625.8		-	10	140.9			2	72.0
4	Говь-Угтаал	15	388.7		-	2	206.8	6	85.4			7	96.6
5	Гурвансайхан	13	963.6	1	90.0	1	36.5	3	37.5			8	799.6
6	Дэлгэрхангай	34	715.9		-	5	312.4	18	152.2			11	251.3
7	Дэлгэрцогт	12	248.3	1	119.2	1	30.0	8	86.2			2	12.9
8	Дэрэн	25	478.8	1	72.8	4	189.6	17	184.9			3	31.5
9	Луус	18	397.7	3	80.9	6	175.8	8	117.4			1	23.6
10	Өлзийт	39	1,384.0	3	272.7	5	360.2	22	324.0			9	427.1
11	Өндөршил	15	699.1	3	472.1	5	157.0	5	64.0	2	6.0		-
12	Сайнцагаан	47	999.8	1	200.0	3	219.9	30	446.5	3	15.0	10	118.4
13	Сайхан-Овоо	21	513.1	2	242.5	1	55.0	14	158.4		-	4	57.3
14	Хулд	21	611.7		-	5	294.5	15	256.5		-	1	60.7
15	Цагаандэлгэр	19	390.2		-		-	17	265.8	1	19.9	1	104.5
16	Эрдэнэдалай	60	1,427.9	7	714.9	2	100.0	33	519.5		-	18	93.5
	нийт дүн	410	18,535.7	57	10,292.9	52	2,771.7	210	2,910.8	6	40.9	85	2,519.4

Хавсралт 7

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, /Гүйцэтгэлээр/
Сая төгрөгөөр

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Тайлант жилд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан ТАХ- ний		Үүнээс							
				Нээлттэй тендер шалгаруулалт	Онцгой журам				Олон нийтийн оролцоотой худалдан авалт		
					Харьцуулалт		Шууд гэрээ байгуулах				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Дундговь аймаг ОНХС	37	5,715.3	29	5,348.1	8	367.2		-		
2	Адаацаг	8	396.1	1	155.3	3	177.4	4	63.4		
3	Баянжаргалан	11	284.9	1	190.9		-	10	94.1		
4	Говь-Угтаал	8	285.1		-	2	204.5	6	80.7		
5	Гурвансайхан	5	148.7	1	89.8	1	24.2	3	34.7		
6	Дэлгэрхангай	23	440.9		-	5	296.0	18	144.8		
7	Дэлгэрцогт	10	227.6	1	116.3	1	29.7	8	81.6		
8	Дэрэн	21	382.8	1	71.1	3	132.5	17	179.2		
9	Луус	17	335.3	3	77.0	6	146.8	8	111.5		
10	Өлзийт	30	779.3	3	243.4	5	244.5	22	291.4		
11	Өндөршил	12	589.7	3	452.1	2	74.0	5	59.1	2	4.5
12	Сайнцагаан	37	807.3	1	173.3	3	199.0	30	422.6	3	12.5
13	Сайхан-Овоо	17	425.7	2	239.1	1	45.0	14	141.6		-
14	Хулд	20	495.0		-	5	257.3	15	237.8		-
15	Цагаандэлгэр	18	254.8		-		-	17	234.9	1	19.9
16	Эрдэнэдалай	43	1,219.8	8	607.5	2	94.1	33	518.2		-
	нийт дүн	317	12,788.4	54	7,763.8	47	2,292.1	210	2,695.5	6	36.9

Хавсралт 8

ДУНДГОВЬ АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Сая төгрөгөөр

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний				Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний			Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	
		тоо	дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	Үүнээс дутуу олгосон санхүүжилт		тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	тоо	дүн
								тоо	дүн					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Аймгийн төв	42	7,885.5	37	6,855.5	31	4,662.9	3	201.3	6	2,192.6	1,273.0	5	439.9
2	Адаацаг	15	592.6	9	427.7	8	415.7		-	1	12.0	-	6	163.3
3	Баянжаргалан	14	838.7	11	295.5	10	285.5		-	1	10.0	5.0	3	477.5
4	Говь-Угтаал	15	388.7	8	290.4	7	280.4		-	1	10.0	7.0	7	96.6
5	Гурвансайхан	13	963.6	5	159.5	4	124.5		-	1	35.0	24.2	8	799.6
6	Дэлгэрхангай	34	715.9	23	455.4	23	455.4		-		-	-	11	251.3
7	Дэлгэрцогт	12	248.3	10	229.5	10	229.5		-		-	-	2	12.9
8	Дэрэн	25	478.8	21	466.9	20	389.2		-	1	77.7	71.3	4	76.5
9	Луус	18	397.7	17	357.6	16	277.4		-	1	80.2	40.9	1	23.6
10	Өлзийт	39	1,384.0	30	896.3	26	692.2		-	4	204.1	93.7	9	427.1
11	Өндөршил	15	699.1	13	614.1	11	574.1		-	2	40.0	20.0	2	58.4
12	Сайнцагаан	47	999.8	37	807.3	36	787.3	1	234.7	1	20.0	10.0	10	118.4
13	Сайхан-Овоо	21	513.1	17	429.2	15	425.9		-	2	3.2	2.2	4	57.3
14	Хулд	21	611.7	20	512.1	19	420.3	2	5.3	1	91.8	80.1	1	60.7
15	Цагаандэлгэр	19	390.2	18	261.0	18	261.0	2	6.2		-	-	1	104.5
16	Эрдэнэдалай	60	1,427.9	42	1,224.2	42	1,224.2		-		-	-	18	93.5
	нийт дүн	410	18,535.7	318	14,282.2	296	11,505.6	8	447.5	22	2,776.6	1,627.3	92	3,261.0

Хавсралт 9

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

Сая төгрөгөөр

№	Сум, дүүргийн нэр	Тухайн онд санхүүжсэн дүн	Үндсэн хөрөнгөөр			
			Үндсэн хөрөнгө	Бараа материал	Урсгал зардлаар	Бүртгэлд тусгаагүй хөрөнгө
1	Аймгийн ОНХС дүн	5,715.3	5,695.7	19.6	-	
2	Дэлгэрцогт сум	227.6	211.0	9.5	7.0	
3	Дэрэн сум	382.8	300.8	12.0	70.1	
4	Говь-Угтаал сум	285.1	260.1	-	25.1	
5	Цагаандэлгэр сум	254.9	157.7	55.0	42.3	
6	Баянжаргалан сум	284.9	250.5	5.0	29.5	
7	Өндөршил сум	589.7	548.7	33.8	7.1	
8	Гурвансайхан сум	148.7	127.1	19.6	2.0	
9	Өлзийт сум	779.3	730.3	-	49.0	
10	Хулд сум	495.0	305.4	46.7	62.8	80.1
11	Луус сум	335.3	296.8	-	17.8	20.7
12	Дэлгэрхангай сум	440.9	405.0	20.8	15.0	
13	Сайхан-Овоо сум	425.7	375.1	42.8	7.8	
14	Эрдэнэдалай сум	1,219.8	1,194.8	8.0	17.0	
15	Адаацаг сум	396.1	365.6	18.4	12.2	
16	Сайнцагаан сум	807.3	785.3	-	22.0	
	АЙМГИЙН ДҮН	12,788.4	12,009.8	291.2	386.6	100.8

Хавсралт 10

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХИЙСЭН ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭНИЙ УМС-Д ОРУУЛСАН БАЙДАЛ

Сая төгрөгөөр

№	Аймаг, сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Үүнээс:					
				ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг					
				Бүрэн оруулсан ТАХ-ний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХ-ний	
0	1	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
2	3	4	5	6	7	8	9		
1	Аймгийн төв	42	7,885.5	35	6,780.7	6	905.6	1	199.2
2	Адаацаг	15	592.6	15	592.6		-		-
3	Баянжаргалан	14	838.7	12	395.6		-	2	443.1
4	Говь-Угтаал	15	388.7	10	323.6		-	5	65.1
5	Гурвансайхан	13	963.6		-		-	13	963.6
6	Дэлгэрхангай	34	715.9	31	593.4		-	3	122.5
7	Дэлгэрцогт	12	248.3	12	248.3		-		-
8	Дэрэн	25	478.8	25	478.8		-		-
9	Луус	18	397.7	18	397.7		-		-
10	Өлзийт	39	1,384.0		-	30	1,230.7	9	153.3
11	Өндөршил	15	699.1	15	699.1		-		-
12	Сайнцагаан	47	999.8		-	37	843.7	10	156.1
13	Сайхан-Овоо	21	513.1		-		-	21	513.1
14	Хулд	21	611.7	21	611.7		-		-
15	Цагаандэлгэр	19	390.2	9	138.9	3	54.2	7	197.1
16	Эрдэнэдалай	60	1,427.9		-	40	1,222.9	20	205.0
	нийт дүн	410	18,535.7	203	11,260.5	116	4,257.1	91	3,018.0

Хавсралт 11


ДУНДГОВЬ АЙМГИЙН 2023 ОНД ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАГНАЛД
ТАВЬСАН ХЯНАЛТ

Сая төгрөгөөр

№	Аймаг, сумын нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		Захиалагчийн хяналт				ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн эсэх			
				Хэрэгжүүлсэн ТАХ		Хэрэгжүүл-ээгүй ТАХ		ИТХ		Дотоод аудит	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тийм	үгүй	тийм	үгүй
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Аймгийн төв	37	5,715.3	37	5,715.3		-	1			1
2	Адаацаг	8	396.1	7	323.5	1	72.6	1			1
3	Баянжаргалан	11	284.9	11	284.9		-	1			1
4	Говь-Угтаал	8	285.1	6	80.7	2	204.5	1			1
5	Гурвансайхан	5	148.7	5	148.7		-	1			1
6	Дэлгэрхангай	23	440.9	20	385.0	3	55.8	1		1	
7	Дэлгэрцогт	10	227.6	9	217.6	1	10.0	1			1
8	Дэрэн	21	382.8	19	295.1	2	87.7	1			1
9	Луус	17	335.3	16	315.9	1	19.4	1			1
10	Өлзийт	30	779.3	26	677.9	4	101.4	1		1	
11	Өндөршил	12	589.7	10	565.2	2	24.5	1		1	
12	Сайнцагаан	37	807.3	31	693.4	6	113.9	1			1
13	Сайхан-Овоо	17	425.7	15	266.2	2	159.5	1			1
14	Хулд	20	495.0	17	388.7	3	106.3	1		1	
15	Цагаандэлгэр	19	254.9	16	195.0	3	59.9	1			1
16	Эрдэнэдалай	43	1,219.8	41	1,144.2	2	75.6	1			1
	нийт дүн	318	12,788.4	286	11,697.3	32	1,091.2	16	0	4	12

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН 502.3 САЯ ТӨГРӨГИЙН ТӨСӨВТ ӨРТӨГТЭЙ
“ЭРДМИЙН ДАЛАЙ ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН ТОХИЖИЛТ

Зураг 1



Номын сан



Бүжгийн танхим



Спортын танхим



Сургалтын танхим



Шатар даам сургалтын танхим



Автомат тоглоомууд



“УНДНЫ УСНЫ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖИЙН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ЭРДЭНЭДАЛАЙ, АДААЦАГ, ӨЛЗИЙТ СУМДАД ХИЙГДСЭН УС ЦЭВЭРШҮҮЛЭГЧ

Зураг 2



Эрдэнэдалай сумын ус цэвэршүүлэг, цэнхэр ионжуулагч

Адаацаг сумын ус цэвэршүүлэгч

Зураг 3

2023 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНЭЭС АШИГЛАЛТГҮЙ БАЙГАА ХӨРӨНГИЙН СУДАЛГАА



0.8 сая төгрөг-автомат даралтын аппарат- 2,

2



4.0 сая төгрөг- гүйлтийн зам -1



1.1 сая төгрөг- хоргүйжүүлэх аппарат-

САЙХАН-ОВОО СУМ



8.0 сая төгрөг- шүдний рентген-1



8.9 сая төгрөг нярайн дулаацуулах ширээ



16.8 сая төгрөг
Ххуванцар, гялгар уут пэрэслэгч машин

ОНХС-ААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС БАТАЛГААТ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГААР
ЗАСВАРЛУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГҮҮД

Зураг 4



Сайнцагаан сумын 19.0 сая төгрөгийн өртөгтэй “Зүүн 4 замын гэрэл дохиог засварлах” ажил - Гэрлэн тохио ажиллахгүй байгаа



Сайнцагаан сумын 407.9 сая төгрөгийн өртөгтэй /БМБХ ШТС-аас Шунхлай ШТС хүртэлх/ 3,5 км улсын чанартай авто замын гэрэлтүүлэгийн ажил- 1 шон гэрлийн толгой байхгүй, зарим шонг машин дайрч, буруу эргэсэн, толгойн хамгаалалт салж үнжсэн.



Аймгийн ОНХС-аар 473.6 сая төгрөгийн өртөгтэй “Жишиг хүүхдийн тоглоом, амралт чөлөөт цаг өнгөрөөх талбай” /5 газарт хийгдсэн/ 3 тоглоомын газрын талбайн зөөлөвч резин нь салаад унасан, арвижих багийн тоглоомын талбайн нэг хогийн сав байхгүй байсан. Мөн зураг төсөв дээрх нийт 7.0 сая төгрөгийн өртөгтэй ногоон байгууламж нь огт хийгдээгүй байна.

ОНХС-ААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС БАТАЛГААТ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГААР
ЗАСВАРЛУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГҮҮД

Зураг 5



Сайхан –Овоо сумын 142.0 сая төгрөгийн өртөгтэй “Наадмын талбайд сүүдрэвч сандлын тоог нэмэгдүүлэх, шинэчилэх” ажлын нэг сүүдрэвчний төмөр дээврийн зарим хэсэг урагдаж хуурсан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 249.8 сая төгрөгийн өртөгтэй “Аймгийн төвийн нийтийн халуун усны их засвар”-ын ажлын шүршүүрийн өрөө, хувцас солих өрөөний хоорондын тусгаарлах ханы хажуу нь усанд норж доод талаасаа халцарч, мөөгөнцөрдөх эрсдэлтэй болсон. Мөн байшингийн орох хэсгийн усны хаялага хагарч эвдэрсэн.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН